

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭСРЭГ ЗАНАЛХИЙЛЛИЙН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ЖУРАМ

1. Зорилго

1.1. Иргэний нисэхийн эсрэг болзошгүй заналхийллийн үед Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл болон тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллага, онцгой байдал, иргэний нисэхийн зэрэг төрийн байгууллагуудаас хэрэгжүүлэх арга хэмжээний харилцан ажиллагааг нэгтгэн зохицуулахад энэхүү журмыг мөрддөг болгоно.

2. Нэр томъёо

Энэ журманд хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

- 2.1. *Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл* гэж нислэг үйлдэж буй болон газарт байгаа агаарын хөлөг, нисэх буудал, иргэний нисэхийн навигацийн тоног төхөөрөмж, барилга байгууламж, зорчигч, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, иргэний нисэхийн аюулгүй байдалд хор хохирол учруулах, нисэхийн аюулгүй ажиллагааг алдагдуулж болзошгүй тухай бодит мэдээлэл бүхий хөндлөнгийн хууль бус үйлдэл гарч болох эрсдэлтэй нөхцөл байдлыг;
- 2.2. *Заналхийллийн түвшин* гэж аливаа шугамаар авсан заналхийллийн талаарх мэдээллийг боловсруулж, үнэлсний дараа үндэсний болон нисэх буудлын түвшинд хүний хүчин зүйл, материаллаг нөөцийг ашиглах замаар сэжиг бүхий төхөөрөмж болон эд зүйлсийг олж илрүүлэх, аюулыг саармагжуулах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зэрэг иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд эрх бүхий байгууллагаас зарлах нөхцөл байдлын хэм хэмжээг;
- 2.3. *Болзошгүй нөхцөл байдал* гэж хөндлөнгийн хууль бус үйлдэл үйлдэгдэх магадлалтай байгаа талаар мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагад тодорхой мэдээлэл байгаа болон бодитой аюул заналхийлэл үүссэн үеийг.

3. Заналхийллийн түвшинг тогтоох, зарлах

3.1. Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэл, учирч болзошгүй аюул, заналхийллийн түвшинг Тагнуулын ерөнхий газраас үнэлэн тогтооно.

3.2. Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшинг дараахь байдлаар ангилан, тогтооно. Үүнд:

3.2.1 Нэгдүгээр түвшин (бага эсхүл "ногоон") – аль нэгэн агаарын тээвэрлэгч, эсхүл нисэх буудал нь халдлагад өртөх талаар бодит мэдээлэл байхгүй боловч хөндлөнгийн хууль бус үйлдэл хийж болзошгүй байгаа үед;

3.2.2 Хоёрдугаар түвшин (дунд эсхүл "шар") – иргэний нисэхийн үйл ажиллагаа нь халдлагад өртөх магадлалтай байна гэж тодорхойлсон мэдээ, мэдээлэл байгаа үед;

3.2.3 Гуравдугаар түвшин (өндөр эсхүл "улаан") – иргэний нисэхийн үйл ажиллагаа нь халдлагад өртөх талаар тусгайлан тодорхойлсон бодит мэдээ, мэдээлэл байгаа үед.

3.3. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрт тусгагдсан дээрх 3 түвшинд авах арга хэмжээ нь иргэний нисэхийн эсрэг заналхийллийн эрсдлийг зохицуулна.

3.4. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл болон Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн эсрэг заналхийллийн талаар авсан мэдээ, мэдээлэлд үндэслэн Тагнуулын ерөнхий газраас үнэлэн тогтоосон заналхийллийн түвшинг дараахь байдлаар зарлаж, түвшин бүрт тохирсон холбогдох арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

3.4.1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь Нэгдүгээр түвшин (бага эсхүл "ногоон") болон Хоёрдугаар түвшин (дунд эсхүл "шар")-г;

3.4.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь Гуравдугаар түвшин (өндөр эсхүл "улаан")-г.

3.5. Заналхийллийн түвшингийн үргэлжлэх хугацааг боломжтой бол тодорхой заана.

3.6. Заналхийллийн нөхцөл байдал намжсан, заналхийлэгчдийг илрүүлж, тогтоон, холбогдох арга хэмжээг бүрэн авсан гэж Тагнуулын ерөнхий газраас мэдээлэл ирүүлсэн бол Нэгдүгээр түвшин болон Хоёрдугаар түвшнийг Иргэний нисэхийн ерөнхий газар, Гуравдугаар түвшнийг Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл тус тус цуцална.

4. Байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хамтын ажиллагаа

4.1. Иргэний нисэхийн эсрэг болзошгүй заналхийллийн үед Тагнуулын ерөнхий газар нь дараахь үүрэгтэй. Үүнд:

4.1.1. холбогдох байгууллагуудыг заналхийллийн талаарх мэдээллээр хангах, мэдээлэл хүргүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.1.2. иргэний нисэхийн эсрэг заналхийлэл эсхүл иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаарх

мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийн, шалгаж Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл болон тусгайлсан чиг үүрэгтэй бусад байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангах;

4.1.3 заналхийллийн түвшинд тохирсон аюулгүй байдлын арга хэмжээ хэрэгжиж буй эсэхэд хяналт тавьж, удирдамжаар хангах.

4.2. Цагдаагийн ерөнхий газар нь дараахь үүрэгтэй. Үүнд:

4.2.1. Тагнуулын ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар болон бусад байгууллагуудтай хамтран аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилгоор үзлэг, шалгалтыг явуулах;

4.2.2. Хоёрдугаар түвшин (дунд эсхүл “шар”) болон Гуравдугаар түвшин (өндөр эсхүл “улаан”)-д заналхийллийн талаарх Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл дээр үндэслэн үүссэн болон үүсэж болзошгүй нөхцөл байдал, хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хойшлуулшгүй ажиллагааг төрийн бусад чиг үүрэг бүхий болон иргэний нисэхийн бусад байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх.

4.3. Иргэний нисэхийн ерөнхий газар нь Тагнуулын ерөнхий газрын тогтоосон заналхийллийн түвшин болон заналхийлэлтэй холбоотой бусад мэдээ, мэдээллийг хүлээн авмагц нисэх буудал, агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн бусад байгууллагад яаралтай хүргүүлэн, тухайн нөхцөлд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мэдээллийг дамжуулахдаа тухайн мэдээллийг бүрэн эхээр нь, тусгайлсан зааварчилгаатай бол хэсэгчлэн хүргүүлнэ.

4.4. Хил хамгаалах ерөнхий газар нь дараахь үүрэгтэй. Үүнд:

4.4.1. иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэл, болзошгүй нөхцөл байдал, аюул, заналхийллийн түвшинг үнэлж, тогтооход Тагнуулын ерөнхий газарт гүйцэтгэх ажлын шугамаар туслалцаа үзүүлэх;

4.4.2. хилийн хяналтын үйл ажиллагаа явуулж буй нисэх буудалд болзошгүй нөхцөл байдал үүссэн тухай болон цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллийг харьяа анги, салбарт хүргэн шуурхай удирдлагаар хангаж, бэлэн байдлыг хангуулах;

4.4.3. болзошгүй нөхцөл байдлын үед хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагааг иргэний нисэхийн байгууллага, нисэх буудал болон хүчний бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.5. Онцгой байдлын ерөнхий газар нь дараахь үүрэгтэй. Үүнд:

4.5.1. агаарын хөлгөөр хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис, цацраг идэвхит болон химийн хортой бодис тээвэрлэгдэн ирж, сэжиг илэрсэн тохиолдолд Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлд мэдэгдэх;

4.5.2. гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг ашигла, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах;

4.5.3. өвчний сэжигтэн болон хавьтагч нарыг тусгаарлах, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхит болон химийн хортой бодисыг аюулгүй болгох зорилгоор агаарын хөлөг, нисэх буудал, иргэний нисэхийн навигацийн тоног төхөөрөмж, барилга байгууламжид зөвхөн мэргэжлийн албан хаагчдыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

4.6. Гаалийн ерөнхий газар нь газар нь дараахь үүрэгтэй. Үүнд:

4.6.1. заналхийллийн зарласан түвшинд хилийн хяналтын бусад байгууллагуудтай гаалийн хяналтын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах;

4.6.2. гаалийн хяналтын үйл ажиллагаа явуулж буй нисэх буудалд болзошгүй нөхцөл байдал үүссэн тухай болон цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллийг харьяа алба, салбарт хүргэн шуурхай удирдлагаар хангаж, бэлэн байдлыг хангуулах;

4.7. Гадаад харилцааны яам нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрээр иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэл, болзошгүй нөхцөл байдал, аюул, заналхийллийн талаар холбогдох гадаад улс орны эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

5. Мэдээлэл хүлээн авах, хүргүүлэх, цуглуулах

5.1. Гадаад харилцааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн эсрэг заналхийлэл, хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаарх болон нисэхийн аюулгүй байдалтай холбоотой өөрсдийн шугамаар хүлээн авсан мэдээ, мэдээллийг Тагнуулын ерөнхий газарт нэн даруй хүргүүлнэ.

5.2 Нисэх буудал, агаарын тээвэрлэгч, иргэний нисэхийн салбарын бусад байгууллагууд нь иргэний нисэхийн эсрэг заналхийлэл, хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаар болон нисэхийн аюулгүй байдлын холбогдолтой мэдээ, мэдээллийг хүлээн авмагц Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдэгдэнэ.

5.3. Тагнуулын ерөнхий газар нь иргэний нисэхийн эсрэг заналхийллийн талаарх болон иргэний нисэхийн аюулгүй байдлын холбогдолтой бүх мэдээ, мэдээллүүдийг тогтмол, шуурхай нэгтгэн цуглуулж, мэдээг үнэлж дүгнэж, заналхийллийг бодитой тогтоох боломжийг бүрдүүлнэ.

5.4. Тагнуулын ерөнхий газар нь нисэхийн аюулгүй байдалтай холбоотой боловсруулсан мэдээллийг иргэний нисэхийн болон тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудад хүргүүлнэ.

5.5 Заналхийллийн талаарх нууцлавал зохих мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд нууцлал бүхий суваг, техник хэрэгсэл ашиглан хүргүүлнэ.

5.6. Нууцлал бүхий суваг, нууцлах программ хангамжийн найдвартай, тасралтгүй ажиллагааг Тагнуулын ерөнхий газар хариуцан ажиллана.

5.7. Мэдээлэл хүргүүлсэн тухай болон хүргэгдсэн мэдээллийн талаар холбогдох байгууллагууд нь нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлсэн байна.

5.8. Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлын холбогдолтой мэдээ, мэдээлэл хүлээн авах байгууллагын хаяг, албан тушаалтан, утасны жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сард багтаан, өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр нь гаргаж Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн дарга, холбогдох гишүүн байгууллагад хүргүүлнэ.

6. Мэдээллийг боловсруулах, нууцлах

6.1. Тагнуулын ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллийн талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.1.1. иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллийн нэгтгэн, дүн шинжилгээ хийж, нисэхийн аюулгүй байдлын мэдээллийн санг бүрдүүлэх;

6.1.2. хүлээн авсан мэдээ, мэдээллийг үнэлж, иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийж, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл, Иргэний нисэхийн ерөнхий газар болон иргэний нисэхийн салбарын бусад байгууллага, албан тушаалтныг лавлагаа, тоон мэдээллээр хангах;

6.1.3. терроризм, терроризмийн шинжтэй гэмт үйлдлээс учирч болзошгүй аюул заналхийллийн талаар мэдээлэл цуглуулах, боловсруулах замаар Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл, Иргэний нисэхийн ерөнхий газрыг холбогдох мэдээллээр хангах.

6.2. Хил хамгаалах ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхэд нь Тагнуулын ерөнхий газарт холбогдох туслалцаа үзүүлнэ.

6.3. Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл, хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаарх мэдээ, мэдээлэл, баримт бичигтэй танилцах болон дээрх мэдээ, мэдээллийг Тагнуулын байгууллагаас хүлээн авах, түүнд дамжуулах ажилтан нь тусгайлан томилогдсон нууцын ажилтан байна.

6.4. Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл, хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаарх мэдээ, мэдээллийг шалгаж тогтоох, тухайн мэдээлэлтэй албан үүргийн шугамаар танилцах итгэмжлэн хариуцсан албан тушаалтан нь Байгууллагын нууцын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тодорхой хүрээ, хугацаанд хадгалах, нууцлах үүрэгтэй.

6.5. Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл, хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаарх мэдээ, мэдээлэл, баримт бичгийг бусдад задруулсан нь эрүүгийн хариуцлага

хүлээлгэхээргүй бол Байгууллагын нууцын тухай хууль, Төрийн нууцын тухай хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7. Шууд заналхийлсэн шуурхай мэдээлэл ирсэн үед хийх зохицуулалт

7.1. Агаарын тээвэрлэгч, нисэх буудал, цагдаа, онцгой байдлын болон тусгайлсан чиг үүрэгтэй бусад байгууллагууд нь заналхийллийн үед гарч болзошгүй осол аюулын онцлогийг агуулсан аюулгүй байдлын болзошгүй заналхийллийн үед ажиллах журмыг тус тусын байгууллагад боловсруулж, хэрэгжүүлнэ.

7.3. Нисэх буудал нь шууд заналхийлсэн шуурхай мэдээ, мэдээлэл авсан үед Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдэгдэж, өөрийн чиг үүргийн дагуу холбогдох шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.4. Нисэх буудлын аюулгүй байдлын алба буюу аюулгүй байдлын хэсэг нь гал унтраах, авран хамгаалах алба болон хэсгийн нийт ажилтныг шуурхай цуглуулах арга хэмжээ авч, тухайн объектын хамгаалалтыг чангатган, бэлэн байдлыг нийт албан хаагчдын дунд зарлана.

7.5. Нисэх буудалд заналхийллийн түвшин зарлагдсан тохиолдолд тухайн нисэх буудлын аюулгүй байдлын хороог хуралдуулна.

7.6. Аюулгүй байдлын хорооны бүрэлдэхүүнд үүссэн нөхцөл байдалд тохируулан, өөрчлөлт орлуулж болно.

7.7. Аюулгүй байдлын хороо нь нөхцөл байдалд дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээг хийх бөгөөд эрсдлийн үнэлгээнд тулгуурлан хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх санал, цаг үеийн байдал, хүн болон материаллаг нөөцийн тооцооны хамт Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлнэ.

7.8. Аюулгүй байдлын хороог хуралдуулж, заналхийллийн эсрэг арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжүүлж эхлэх хүртэл хугацаанд Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн 13 дугаар бүлэгт заасны дагуу иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үеийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

8. Заналхийллийн Нэгдүгээр түвшин (бага эсхүл "ногоон")-ий үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

8.1. Заналхийллийн бүх түвшинд үндэслэн авч хэрэгжүүлэх аюулгүй байдлын арга хэмжээ нь иргэний нисэхийн эсрэг дараахь үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэгдсэн байна. Үүнд:

8.1.1. агаарын хөлгийн гадна, эсхүл дотор талд тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, хэрэгсэл болон бодис байрлуулж, түүнийг устгах, гэмтэл учруулах;

8.1.2. агаарын хөлөг, түүний зорчигч, нисэх багийг барьцаалах;

8.1.3. нислэг үйлдэж буй агаарын хөлөг, түүний зорчигч, нисэх багийн аюулгүй байдалд аюул учруулах;

- 8.1.4. хориотой болон хамгаалагдсан бүсэд хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй хэрэгсэл, бодис, эсхүл зэвсэг, зэвсгийн чанартай эд зүйлс нэвтрүүлэх;
- 8.1.5. тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, хэрэгсэл болон тэсрэх бодис байрлуулан агаарын навигацийн байгууламжийг устгах, гэмтээх, иргэний нисэхийн үйл ажиллагаанд саад учруулах;
- 8.1.6. нисэх буудалд тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, хэрэгсэл болон тэсрэх бодис байрлуулан олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах.

8.2. Нисэх буудал, агаарын тээврийн байгууллагууд нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр болон нисэх буудал, агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг тус тус авч хэрэгжүүлнэ.

8.3 Агаарын хөлөг, нисэх буудал, нисэх буудлын объект, агаарын навигацийн байгууламж, агаарын хөлгөөр зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор аюулгүй байдлын байнгын бэлэн байдлыг хангаж, нийт албан хаагчид өөрсдийн чиг үүргийн дагуу хяналтыг өндөржүүлэн ажиллана.

8.4. Нисэх буудал нь нисэх буудлын аюулгүй байдал, хамгаалалтын албаны болон аюулгүй байдлын хэсгийн ээлжийн бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангаж, үзлэг шалгалтыг нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсан шаардлагын дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

- 8.4.1 үүсч болзошгүй цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллийг тасралтгүй цуглуулан нэгтгэж, Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлнэ;
- 8.4.2 аюулгүй байдлын өдөр тутмын бэлэн байдлыг хангаж, албаны бие бүрэлдэхүүний хүн нэг бүрийн томилгооны хуваарь, үүргийг тодорхой болгоно;
- 8.4.3 цагдаа, хил хамгаалах, хилийн хяналтын болон тусгайлсан чиг үүрэгтэй бусад байгууллагуудтай мэдээ, мэдээлэл солилцож, харилцан ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлж ажиллана;
- 8.4.4 нисэх буудал дахь түрээслэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд өндөржүүлсэн хяналтыг тавьж, хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.
- 8.4.5 нисэх буудалд үйлчлүүлж буй иргэдийн дунд сэжигтэй үйлдэл гарч болзошгүй хэсгүүдийг хяналтанд авна;
- 8.4.6 агаарын хөлөгт зорчигчдын амь насанд халдах зорилгоор хоол хүнсийг хордуулах биотерроризм иргэний нисэхийн үйл ажиллагаа болон агаарын навигацийн аюулгүй ажиллагаанд халдаж болзошгүй кибертерроризмын халдлагаас урьдчилан сэргийлнэ;
- 8.4.7 нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүс орчимд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч, иргэний нисэхийн хэвийн үйл

ажиллагаанд саад учруулахаас урьдчилан сэргийлнэ.

8.5. Цагдаагийн ерөнхий газар нь заналхийллийн талаар мэдээ, мэдээллийн бодит байдалд үнэлэлт өгч, нийслэлд Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн бие бүрэлдэхүүнийг, хөдөө орон нутагт тухайн аймгийн цагдаагийн газар, хэлтсүүдийн бие бүрэлдэхүүнийг албаны бэлэн байдалд оруулж, үүрэг чиглэл өгнө. Үүнд:

- 8.5.1 заналхийлэлд өртсөн объектын талаарх шаардлагатай судалгаануудыг холбогдох газруудаас авч, удирдлагыг мэдээллээр хангана;
- 8.5.2 харъяа байгууллагуудтай байнгын холбоотой байж, тэднээс мэдээ, мэдээллийг нэгтгэн авч, цагийн байдалд үнэлэлт өгөх, эргүүлүүдийг ажиллуулах талаар тодорхой үүрэг чиглэл өгнө;
- 8.5.3 удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэж, Нэгдүгээр түвшинг цуцлах буюу түвшинг нэмэх тохиолдолд цаашдын арга хэмжээг авна.

8.6. Онцгой байдлын ерөнхий газар нь үүсч болзошгүй цагийн байдлын талаарх мэдээ мэдээллийг тасралтгүй цуглуулан, харъяа ангиудад хүргэнэ.

8.7. Аврах тусгай ангийн шүхэрчин-аврагч болон эрэн хайх, аврах бүлгийн дуудлага хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж, болзошгүй осол гарах үеийн даргын шийдвэр гарахыг хүлээж, бие бүрэлдэхүүний нэг бүрийн хамгаалах хувцас, аврах тоног төхөөрөмж, хэрэгсэл, хүнс, шатахууны тооцоог хийнэ.

8.8. Хил хамгаалах ерөнхий газар нь үүсч болзошгүй цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллийг тасралтгүй цуглуулан нэгтгэж, харилцан ажиллагаатай байгууллагууд болон нисэх буудалд үйл ажиллагаа явуулдаг харъяа анги, салбаруудад хүргэж, дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 8.8.1 анги салбаруудын шуурхай жижүүрлэлтийн албанд холбогдох үүрэг, чиглэл өгнө;
 - 8.8.2 нисэх буудал, хилийн хяналтын байгууллагууд болон Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэстэй харилцан мэдээ, мэдээлэл солилцож, хамтын ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлно.
- 8.9. Хилийн 0218 дугаар анги нь дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- 8.9.1. өдөр тутмын бэлэн байдлыг хангаж, ангийн бие бүрэлдэхүүний "Цугларалт" дохиогоор ажиллах төлөвлөгөө, бүлэг, хүн нэг бүрийн томилгооны хуваарь, үүргийг тодорхойлж, зааварчилга өгнө;
 - 8.9.2. Хил хамгаалах ерөнхий газраас ирүүлсэн үүргийг хэрэгжүүлж, цагийн байдлын мэдээ, мэдээллийг холбогдох хэлтэс, албадад шуурхай хүргэнэ.
- 8.10. Гаалийн ерөнхий газар нь харъяа гаалийн газрын хяналтыг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч, холбогдох үүрэг, чиглэл өгнө.

8.11. Нисэх буудал дээрх гаалийн хяналтын газар нь Гаалийн ерөнхий газраас өгсөн үүргийг хэрэгжүүлж, тухайн өдрийн ээлж нь ажлыг томилсон хуваарийн дагуу зохион байгуулах үүрэг гүйцэтгэнэ.

8.12. Агаарын тээвэрлэгч нь дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 8.12.1. үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангана;
- 8.12.2. нислэгийн өмнөх болон нислэгийн дараахь аюулгүй байдлын үзлэгийг шалгах хуудсын дагуу хийж гүйцэтгэнэ;
- 8.12.3. зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх явцдаа тандалт хийж гүйцэтгэнэ;
- 8.12.4. агаарын тээвэрлэгчийн ажилтан, тээврийн хэрэгслийг хамгаалагдсан болон хориотой бүсэд нэвтрүүлэхдээ аюулгүй байдлын үзлэг хийлгэнэ;
- 8.12.5. ачаа, шуудан, тээшийг байнгын хяналтанд байлгаж, агаарын хөлөг ачихаас өмнө аюулгүй байдлын үзлэг хийлгэнэ;
- 8.12.6. нислэгийн үед өөрийгөө хянах чадваргүй зорчигчийн үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна;
- 8.12.7. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг ханган ажиллах явцад гарсан аливаа зөрчлийг Иргэний нисэхийн дүрэм 12 дагуу Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдээлнэ.

9. Заналхийллийн Хоёрдугаар түвшин (дунд эсхүл "шар")-ий үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

9.1. Нисэх буудал нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн 13.5-д заасан нэмэлт арга хэмжээнээс гадна дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 9.1.1. зорчигчид, тэдгээрийн гар тээшийг аюулгүй байдлын үзлэгийн цэг дээр шалгахаас гадна нэг нислэгийн зорчигчдын 10-аас доошгүй хувийг хүзүүвчний гарц дээр дахин шалгана;
- 9.1.2. бүх ачаа, илгээмж болон шууданд аюулгүй байдлын үзлэг шалгалт хийсний дараа 24 цагийн турш хадгалж, аюулгүй байдлыг хангана.

9.2. Цагдаагийн ерөнхий газар нь нийслэлд Нийслэлийн цагдаагийн газрын даргын тушаалаар Хан-Уул дүүргийн болон Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн бие бүрэлдэхүүнийг, орон нутагт тухайн аймгийн цагдаагийн газар, хэлтсийн даргын тушаалаар бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэгт оруулж, холбогдох үүрэг чиглэлийг өгнө.

9.3. Цагдаагийн ерөнхий газар нь дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

9.3.1 заналхийлэлд өртсөн объект, заналхийлэгчийн талаарх мэдээ, мэдээллийг авч, холбогдох байгууллагуудад тогтмол мэдэгдэж, шуурхай арга хэмжээ авч байх түр штабыг байгуулан, гишүүдийг томилж ажиллуулна;

9.3.2. цагийн нөхцөл байдлын өрнөлтийн талаар мэдээ, мэдээлэл, үйл явцад штабаас үнэлэлт дүгнэлт гаргаж, шаардлагатай хойшлуулшгүй ажиллагааг гүйцэтгэнэ;

9.3.3. хамтран ажиллах бусад байгууллагуудтай холбоотой байж, тэдний бэлэн байдал болон хүн хүчний талаарх бусад мэдээллийг авч, шаардлагатай техник хэрэгслийг бэлдүүлэх ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэнэ;

9.3.4. түвшинг цуцлах буюу түвшинг нэмэх тохиолдолд удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу ажиллана.

9.4. Онцгой байдлын ерөнхий газар нь шуурхай ажлын хэсэг томилон ажиллуулж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийг шуурхай удирдлагаар хангаж, дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

9.4.1. болзошгүй ослын үед ажиллах тухай даргын шийдвэр чиглэл, дохио дамжуулах болон ослын газар ажиллах заавар, зөвлөмж өгч гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийнэ;

9.4.2. ослын голомтод ажиллах бие бүрэлдэхүүнийг нэгдсэн холбооны сүлжээнд шилжүүлж, үүрэг гүйцэтгүүлэхэд бэлэн болгоно;

9.5. Болзошгүй ослын үед ажиллах шүхэрчин-аврагч болон эрэн хайх, аврах бүлэг нь дуудлага хүлээн авч, тогтоосон газарт хүрэлцэн очин аюулгүй байдлаа бүрэн ханган, үүрэг гүйцэтгэхэд бэлэн болно.

9.6. Шүхэрчин-аврагч болон эрэн хайх, аврах бүлэг нь ослын голомтод очих нөхцөл байдлын тухай мэдээлэл хүлээн авч, эрэн хайх, аврах ажлын боловсруулсан аргачлал, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу үүрэг гүйцэтгэхэд бэлэн болно.

9.7. Хил хамгаалах ерөнхий газар нь үүссэн цагийн байдлын талаарх мэдээ, мэдээллийг харилцан ажиллагаатай байгууллагууд болон нисэх буудалд үйл ажиллагаа явуулдаг харьяа анги, салбаруудад хүргэж, шуурхай удирдлагын бүлэг томилон ажиллуулж, анги салбаруудыг удирдлагаар хангана.

9.8. Хилийн 0218 дугаар анги нь "Онцгой нөхцөл, байдал үүссэн үеийн ажиллах төлөвлөгөө"-г болзошгүй хувилбар бүрээр тодотгож, бие бүрэлдэхүүнийг үүрэг, чиглэлээр ханган ажиллана. Үүнд:

9.8.1. шаардлагатай тохиолдолд ангийн захирагчийн захирамж гаргаж, хил хамгаалалтыг өөрчлөн зохион байгуулна;

9.8.2. штабаас хилийн шалган нэвтрүүлэх заставт офицер ажиллуулж, ангийн захирагчийн орлогч нарыг эргүүлд томилно;

- 9.8.3. хилийн хяналтын бүсэд нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах буюу зогсоож, зарим төрлийн манааг тусгай хэрэгслээр хангана;
- 9.8.4. бие бүрэлдэхүүний амралт, чөлөөг зогсоож, бэлтгэл хүчийг байнгын бэлэн байдалд байлгана;
- 9.8.5. цагийн байдлын өрнөлтийн болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээг Хил хамгаалах ерөнхий газрын шуурхай удирдлагын бүлэг, шуурхай жижүүрт тухай бүр мэдээлнэ.

9.9. Гаалийн ерөнхий газар нь шаардлагатай тохиолдолд газрын даргын тушаал гаргаж, тухайн нисэх буудал дээрх гаалийн газрын хяналтын технологи, дарааллыг өөрчлөн зохион байгуулна.

9.10. Гаалийн ерөнхий газар нь тухайн нисэх буудал дээрх гаалийн газрын хяналтын үйл ажиллагааг хилийн хяналтын бусад байгууллагуудтай уялдуулан, шуурхай зохион байгуулж, удирдлагаар хангана.

9.11. Агаарын тээвэрлэгч нь Иргэний нисэхийн ерөнхий газар болон бусад байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангаж, дараахь арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- 9.11.1. заналхийллийн талаар мэдээлэл хүлээн авмагц анхан шатны мэдээллийн хуудсыг нэн даруй Иргэний нисэхийн ерөнхий газарт өгч, тухайн нислэгтэй холбоотой тээврийн болон бусад баримт бичгүүдийг бүрэн бүрдүүлж хүргүүлнэ;
- 9.11.2. өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа хэсэг тус бүр дээр хянагч байрлуулна;
- 9.11.3. зорчигчдын дунд тандалтын үйл ажиллагааг идэвхжүүлж, сэжигтэй зүйл илэрвэл аюулгүй байдлын алба, ажил үүргээ гүйцэтгэж байгаа цагдаагийн албанд мэдэгдэж хамтран ажиллана;
- 9.11.4. газрын үйлчилгээний ажилтнуудыг агаарын хөлөгт ороход аюулгүй байдлын гар үзлэг хийлгэх ажлыг зохион байгуулна;
- 9.11.5. нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг булаан эзэлсэн буюу булаан эзлэхээр заналхийлсэн тохиолдолд Нислэгийн хөдөлгөөн удирдлагын алба болон Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдээлж, тусгайлсан зааварчилгаа өгтөл тухайн үед ажиллах зааврын дагуу ажиллана;
- 9.11.6. нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, хэрэгсэл болон тэсрэх бодисоор заналхийлсэн тохиолдолд шалгах хуудасны дагуу газар дээрх үзлэгийг хийж, сэжигтэй эд зүйлийн талаар Нислэгийн хөдөлгөөнийг удирдах албанд мэдээлж, зохих арга хэмжээг зааврын дагуу авч, ойрын аэродромд буулт хийнэ;

- 9.11.7. болзошгүй ослын үед агаарын тээвэрлэгч нь өөрийн зааврын дагуу ажиллана;
- 9.11.8. авсан арга хэмжээний талаар Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдээлж, тайлан хүргүүлнэ.

10. Заналхийллийн Гуравдугаар түвшин (өндөр эсхүл “улаан”)-ий үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

10.1 Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн Гуравдугаар түвшингийн үед Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийн 13.6-д заасан нэмэлт арга хэмжээнээс гадна дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

10.1.1. Заналхийлэл үүссэн нисэх буудлын тухайн хэсгийн үйл ажиллагааг зогсоож, онцгой байдлыг өндөржүүлэн, объектыг хууль хяналт, мэргэжлийн байгууллагуудын тусгай хамгаалалтанд авна;

10.1.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн дэргэд “Ажиллагааны удирдлагын бүлэг”-ийг байгуулж ажиллана.

10.2. Нисэх буудал нь нисэх буудлын аюулгүй байдлын хороог хуралдуулж, дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

10.2.1. нисэх буудлын хориотой бүсэд харъяалагддаггүй хэсгийг хориотой бүс болгон тогтоож, энэ бүсэд нэвтрэх ажилтнууд, тэдгээрийн эд зүйлс, тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийнэ;

10.2.2. хамгаалагдсан болон нийтийн эзэмшлийн бүсүүд, нисэх буудлын нийт талбайг байнгын харуул хамгаалалтад авна;

10.2.3. агаарын хөлөгт зорчигч суухаас өмнө болон ачаа, илгээмж, шууданг ачихаас өмнө аюулгүй байдлын үзлэг, шалгалтыг дахин хийнэ;

10.2.4. зорчигч, тэдгээрийн гар тээшийг аюулгүй байдлын үзлэгийн цэг дээрээс гадна явах гарц дээр дахин шалгана;

10.2.5. Иргэний нисэхийн ерөнхий газраас шаардсан бусад арга хэмжээг авна.

10.3. Цагдаагийн ерөнхий газар нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлд төлөөлөгч ажиллуулж, Шуурхай удирдлагын төвөөр дамжуулан, анги байгууллагуудыг удирдлагаар хангаж, дараахь дараахь арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

10.3.1. Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын тусгай бүлэг, дотоодын цэрэг гэх зэрэг Нийгмийн хэв журам хамгаалах газрын бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдалд оруулж, ажиллуулна;

10.3.2. заналхийлэлд өртсөн объект, түүний орчимд байгаа байгууллагуудын ажиллагсад болон иргэдийг аюулгүй байдалд шилжүүлэн нүүлгэх ажлыг

зохион байгуулж, онц чухал объектуудыг дотоодын цэргийн хамгаалалтанд авна;

- 10.3.3. онцгой байдал үүссэн үед хэрэгжүүлэх бүх төрлийн төлөвлөгөөг бэлэн болгож, бие бүрэлдэхүүнийг зааварчилгаагаар үүрэгжүүлнэ;
- 10.3.4. заналхийллийг арилгах, илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаануудыг гүйцэтгэхэд холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллана;
- 10.3.5. заналхийллийн үед ажилласан үйл ажиллагааны үр дүнг тооцож, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж, тайлагнана.

10.4. Онцгой байдлын ерөнхий газар нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлд төлөөлөгч ажиллуулж, Шуурхай удирдлагын төвөөр дамжуулан харъяа алба, байгууллагуудыг удирдлагаар хангаж, дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 10.4.1 шүхэрчин-аврагч болон эрэн хайх, аврах бүлэг, болзошгүй аюулын үед эрэн хайх, аврах, гамшгийн голомтоос нэрвэгдэгсдийг гаргах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг эхлүүлэхэд бэлэн байлгана;
- 10.4.2. заналхийллийн Нэгдүгээр болон Хоёрдугаар түвшний арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;
- 10.4.3. Нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах комиссын үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлнэ;
- 10.4.4. болзошгүй аюул тохиолдсон үед зорчигчид, нисэх багийн гишүүдийг аврах, заналхийллийн голомтоос гаргах зөөвөрлөх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, нэрвэгдэгсдийг тээвэрлэх, холбоо харилцааг тогтоох, хүч нэмэгдүүлэх болон шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

10.5. Хил хамгаалах ерөнхий газар нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлд төлөөлөгч ажиллуулж, Шуурхай удирдлагын төвөөр дамжуулан анги, салбаруудыг удирдлагаар хангаж, дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 10.5.1. нисэх буудалд үйл ажиллагаа явуулдаг анги, салбаруудыг албаны өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлж, Хил хамгаалах ерөнхий газрын даргын бэлтгэл хүчийг бэлэн байдалд байлгана;
- 10.5.2. шаардлагатай тохиолдолд анги, салбарт төлөөлөгч томилон ажиллуулж, үйл ажиллагааг шууд удирдуулна;
- 10.5.3. Хилийн 0218 дугаар ангийн бие бүрэлдэхүүнийг албаны өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлж, болзошгүй цагийн байдлын дагуу ажиллахад бэлэн байлгана;
- 10.5.4. олон улсын нисэх буудлын аюулгүй байдлын хороонд төлөөлөгч ажиллуулж, шуурхай удирдлагын болон ажиллагааны бүлгийг удирдлагаар хангана;

10.5.5. зорчигчийн бүртгэл явагдаж байгаа үед шалгалтыг зогсоож, агаарын хөлгийг хүзүүвчнээс нэн даруй салгуулж, хилийн хяналтын бүсийг чөлөөлнө;

10.5.6. нисэх буудлын аюулгүй байдал, хамгаалалтын алба болон хэсэг, тухайн орон нутгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран үүссэн цагийн байдалд тохирсон харилцан ажиллагааны төлөвлөгөөний хувилбарын дагуу үйл ажиллагааг явуулна.

10.5.7. шаардлагатай тохиолдолд бэлтгэл хүчийг зэвсэг, галт хэрэгслээр хангана.

10.6. Гаалийн ерөнхий газар нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлд төлөөлөгч ажиллуулж, нисэх буудал дахь гаалийн газрын хяналтын бүсийн дэглэмд өөрчлөлт оруулах ажлыг шуурхай зохион байгуулж, шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10.7. Агаарын тээвэрлэгч нь Иргэний нисэхийн ерөнхий газар болон бусад байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангаж, заналхийллийн Хоёрдугаар түвшний арга хэмжээнээс гадна дараахь арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

10.7.1. агаарын хөлөгт тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, хэрэгсэл болон тэсрэх бодис нууж болзошгүй байрлал, хэсгүүдийг тодорхой тайлбарлан өгч, агаарын хөлгийн аюулгүй байдлын үзлэгийг Онцгой байдлын ерөнхий газрын саперын албаар гүйцэтгүүлнэ;

10.7.2. Нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг тэсэрч дэлбэрэх төхөөрөмж, хэрэгсэл болон тэсрэх бодисоор заналхийлсэн тохиолдолд шалгах хуудасны дагуу үзлэгийг хийж, сэжигтэй эд зүйлийн талаар нислэгийн хөдөлгөөнийг удирдах төвд мэдээлж, шаардлагатай арга хэмжээг авч, ойрын аэродромд буулт үйлдсэний дараа зорчигчдыг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулна.

11. Онцгой анхаарлын цэг болон аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ

11.1 Ерөнхий газар нь аюулгүй байдлын аудит, үзлэг шалгалт, судалгаа, сорилт, дадлага сургуулилтын үр дүн, тайлангуудад үндэслэн Онцгой анхаарлын цэгийн үнэлгээг гүйцэтгэнэ. Онцгой анхаарлын цэгийн үнэлгээг НААХЗАлбанаас ИКАО DOC-8973-ын дагуу гаргасан "Эрсдлийн удирдлага" заавраар гүйцэтгэх бөгөөд энэхүү үнэлгээ нь урьдчилан авах арга хэмжээний зөвлөмжид ашиглагдана.

11.2 Тагнуулын ерөнхий газраас ИКАО DOC-8973-ын 4-р хавсралтын дагуу тогтоосон заналхийллийн үнэлгээ болон онцгой анхаарлын цэгийн үнэлгээг үндэслэн эрсдлийн матрицаар үнэлгээг гүйцэтгэнэ.

11.3 Байгууллагуудын эрсдлийн үнэлгээ хийгдсэн байдалд "Иргэний нисэхийн аюулгүй байдлын чанарын хяналтын хөтөлбөр"-ийн дагуу Ерөнхий газраас хяналт тавина.

11.4 Иргэний нисэхийн аюулгүй байдлын Эрсдлийн үнэлгээг Ерөнхий газар нь Иргэний нисэхийн Аюулгүй байдлын зөвлөлийн хуралд танилцуулах ба судалгааны дагуу авах арга хэмжээг зөвлөлийн хуралд санал болгож шийдвэрлүүлнэ.

11.5 Судалгаан дээр үндэслэн Аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан шийдвэрүүдийг холбогдох байгууллагууд нь хэрэгжүүлэх ба хэрэгжилтэд Ерөнхий газрын зүгээс хяналт тавьж ажиллана.

12. Үйл ажиллагааны санхүүжилт

12.1. Заналхийллийн түвшинг нэмэгдүүлсэн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг холбогдох байгууллагууд тус тусын төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

--- оОо ---

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2010 оны 03 дугаар
сарын 19 -ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар тогтоолын 2 дугаар заалт болон уг тогтоолын 20 дугаар хавсралтын 29 дэх хэсэг, "Үндэсний хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолоор баталсан "Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр"- ийн 13.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.
2. "Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам"-ыг 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. "Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам"-ын хэрэгжилтийг ханган, энэхүү журмыг үндэслэн агаарын тээвэрлэгч, нисэх буудал, хууль хяналт, онцгой байдлын болон холбогдох бусад байгууллагын болзошгүй заналхийллийн үед ажиллах журмыг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн дэд дарга Тагнуулын ерөнхий газрын Хоёрдугаар газрын дарга П.Баярсайхан, тус зөвлөлийн гишүүн, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Г. Даваа нарт үүрэг болгосугай.
4. "Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам"-ыг Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн бодлогын газар (Б.Махбал)-т даалгасугай.

САЙД

Х.БАТТУЛГА

Танилцуулга

“Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам”-ын тухай

“Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журам”-ын төслийг Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудын оролцоотойгоор Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын ажлын албанаас боловсруулсан болно.

Журмыг баталгаажуулах шатанд Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийн 13.3-т “Нисэх буудал, агаарын тээвэрлэгч, ачаа тээвэр зуучийн болон цагдаагийн байгууллага, холбогдох бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүднээс эдгээр байгууллагын үүрэг, хариуцлагыг Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журамд тодорхой тусгана.” гэж заасны дагуу журмын төсөлд Хил хамгаалах ерөнхий газар болон хилийн цэргийн 0218 дугаар ангиас бусад байгууллагын оролцоо тодорхойгүй байсан, мөн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийн 13.5 болон 13.6-д заасан иргэний нисэхийн эсрэг заналхийллийн хоёр болон гуравдугаар түвшингийн үеийн нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэхэд ямар байгууллага хэрхэн оролцохыг тодорхой болгох, заналхийллийн түвшин бүрт байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой тусгах шаардлагатай гэж үзэж дахин боловсруулалтанд буцаасан юм.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын ажлын албаар журмын төслийг дахин хэлэлцүүлж, байгууллагуудын үүрэг, чиглэлийг заналхийллийн түвшин бүрээр оруулж, боловсруулж ирүүлснийг хянан үзэж, журмын төлийн эцсийн хувилбарыг танилцуулж байна.

Журмын төсөлд Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийн заалтуудыг тэр чигээр нь хуулбарлан, байгууллагуудын чиг үүргийг заналхийллийн түвшин бүрт дахин давтан оруулсан байсныг найруулж, Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийн заалтад нийцүүлэн агуулга, найруулгыг хянаж, холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.

Мөн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрт тодорхой тусгаагүй ерөнхий байдлаар оруулсан байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгосон, тухайлбал заналхийллийн түвшинг Тагнуулын ерөнхий газраас үнэлэн, тогтоож, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл болон Иргэний нисэхийн ерөнхий газраас заналхийллийн түвшинг зарлах, цуцлах, иргэний нисэхийн эсрэг болзошгүй заналхийллийн үед тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах, онцгой байдлын зэрэг байгууллагуудын үүрэг оролцоо, хэрэгжүүлэх арга хэмжээний харилцан ажиллагааны зохицуулалтыг тусгасан болно.

Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед мэдээ, мэдээлэл хүлээн авах утасны жагсаалтыг журмын хавсралтаар батлах нь утас, хаяганд өөрчлөлт орох бүрт Сайдын тушаалаар өөрчлөлт оруулахаар байгаа тул энэ мэдээллийг Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудад Иргэний нисэхийн ерөнхий газраас жил бүрийн 1 дүгээр сард гарган, өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр нь шинэчлэн хүргүүлж байх зохицуулалтыг оруулсан болно.